



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/36

Хэрлэн сум

Байнгын ажиллагаатай  
салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.4 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 95 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутаг, хот суурин газрын газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг хийх, орон сууц, олон нийтийн зориулалтын барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чанар аюулгүй байдлыг үзэж шалгах, паспортжуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг хүчитгэх, буулгаж шинээр барих хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийг байгуулсугай.

Хоёр. Байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


Гурав. Салбар зөвлөлийн ажиллах журам, 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА



## САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: -Аймгийн Засаг даргын орлогч;
- Зөвлөлийн орлогч дарга: -Онцгой байдлын газрын дарга  
-Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын дарга
- Зөвлөлийн гишүүд: -Засаг даргын Тамгын газрын дарга  
-Засаг даргын Тамгын газрын Цэргийн  
штабын дарга  
-Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга  
-Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга  
-Эрүүл мэндийн газрын дарга  
-Боловсрол, соёл, урлагийн газрын  
дарга  
-Цагдаагийн газрын дарга  
-Мэргэжлийн хяналтын газрын дарга  
-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд  
Чингис хотын Захирагч  
-Ус, цаг уур, орчны шинжилгээний  
албаны дарга  
-Авто тээврийн төвийн дарга  
-Автозамын засвар арчлалтын  
"Харгуй" ТӨК-ий захирал
- Нарийн бичгийн дарга: -Онцгой комиссын нарийн бичгийн  
дарга  
-ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн  
бодлогын хэлтсийн дарга